

НОГООННУУР СУМЫН БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас:70422954
Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг: : jekbay01@yahoo.com

Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 89838414
Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.bayan-ulgii.tvet.gov.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /БӨА-2018/16/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 12-ноос 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн аудитор Б.Үүрийнтуяа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 25-нд аймаг дах Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 23-ноос 2 дугаар сарын 26-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 27-нд Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь иргэнд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”, 2.1-д “Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны төсвийг аймгийн ТЭЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Ногооннуур сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр 19 эрсдэлтэй асуудалд 19 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж мөрдөн ажиллаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцолох төв ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн төсвийн захирагчид 2017 онд 1290,9 сая төгрөгийн батлагдсан төсөв, 116 орон тоогоор үйл ажиллагаа явуулахаар тусгагджээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлэгээр 1290,9 сая төгрөгийн санхүүжилт авч, хүүгийн орлогоос 0,03 сая төгрөгийн орлого оруулан бүгд 1290,93 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзэхэд зардлуудыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсныг батлагдсан төсөвт нэмж өгснөөр хэмнэлт хэтрэлт гараагүй байна.

Тус сургуулийн 2017 оны орон тоог удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 64, үйлчилэх ажилтан 43, гэрээт 10 бүгд 116 орон тоогоор баталсанаас гүйцэтгэлээр тайлант онд 1 аж ахуйн эрхлэгч, 1 сав угаагчийн орон тоог шинээр авч 118 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулжээ.

Шилэн дансны мэдээлэл

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2017 оны 1-9 дүгээр сарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар зөрчил илрээгүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин, НДШ, ХХОАТ, гэрэл цахилгаан, түлш халаалт, үдийн цай, хоол, тэтгэвэр тэтгэмж зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3.1/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, мөнгөн хөрөнгийн 100 хувь, нийт зардлын 40-50,0 хувь нь хамрагдсан болно.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил илрээгүй байна. Материаллаг дараах асуудал байна. Үүнд:

1. Тус сургуулийн захирлын шийдвэрээр 2017 оны 10-р сарын ажиллагсадын гарт олгох цалингаас Нийгмийн даатгалын тухай хуулиар тогтоосон хувь хэмжээг зөрчиж 5803.0 мянган төгрөгийн шимтгэлийг 11 хувиар илүү суутгаж, НДШ-ийн өглөгийг барагдуулсан. ҮДТайланд цалингийн зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”, 1.3-т “нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах;” Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх

ажил, гүйлгээ” , 14.4.3 “бүх өр төлбөр”, 14.4.6 “бүх зардал” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөгдөв.*

2. Сургуулийн захиралын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байсан хавсралтанд заасан нэр бүхий ажилчдад Засгийн газраас олгосон 300000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулалыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4-т “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар “Урамшуулал олгох тухай” тэмдэглэлд “УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчид 300000 төгрөгийн урамшуулал олгох тухай асуудлыг хэлэлцээд сахилгын шийтгэл хүлээсэн бөгөөд сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байгаа албан хаагчаас бусад төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох арга хэмжээ авахыг төсвийн шууд захиргч нарт даалгав” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Төсөвт нөхөн төлүүлэхээр акт тогтоов.*

3. Тус сургуулийн 2017 оны төсөвт орон тооны хязгаарыг 116 хүнээр баталсан боловч гүйцэтгэлээр 118 орон тоо ажилуулж, орон тоог 2-оор илүү ажиллуулсан байна. 2017 онд шинээр 1 аж ахуйн эрхлэгч ТҮ-5-1, 1 сав угаагч ТҮ-1-1 шатлалаар батлагдсан орон тооноос илүү ажиллуулж ирсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2,16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дах заалтууд болон Улсын Их хурлын 2016 оны 69 дүгээр тогтоолын 3-ийн 1 дэх заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: *Ажлаас халах санал хүргүүлэхээр болов.*

4. Хоолны зардлын батлагдсан төсвөөс бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авахад 10987.0 мянган төгрөгийг төрийн сангийн зохих зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн 42.3, 42.4 дэх заалтууд болон Сангийн сайдын 2013 оны "төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.2-т "аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн захирагчаас ирүүлсэн саналыг судлан үзээд зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд тухайн зардлын бүлгийн батлагдсан төсвийн жилийн дүнгийн 120 хувиас хэтрэхгүй, 10.0 сая төгрөг хүртэлх зохицуулалтыг хийж...баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: *Асуудлын бүртгэлд оруулж ТТЗ-ийн тайлангаар албан шаардлага өгөхөөр болов.*

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах дансдын тооцооллыг гүйцэд даган мөшгин шалгах боломжгүй байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө, бараа материалын биет тооллого хийх боломжгүй учраас гүйцэтгэлийн шалгалтаар хөрөнгийг биет ажиглалтаар тоолох шаардлагатай.
2. Цалин хөлс, НДШ-ийн зардлыг давтан тооцоолох, томоохон зардлуудыг цаг хугацааны шахуу байдлаас үүдэн түүврийн аргаар үзсэн тул нэмж үзэх шаардлагатай. Аудитын явцад сургуулийн харилцагч банкны цалингийн дансны 1-12-р сарын хуулга, үлдэгдлийн баталгааг ирүүлээгүй.
3. Санхүүгийн тайланг программаар гаргадаггүй учраас үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг дахин тооцоолох шаардлагатай. Аудитын хугацаанд элэгдлийн тооцооллыг ирүүлээгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 заалт бүхий 8,6 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах зөвлөмж өгөгдөж, биелэлтийг ирүүлсэн байна.

Зөвлөмж

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд зөвлөмж өгөх асуудал гараагүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ногооннуур сумын Бүрэн дунд сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

Огноо: 2018.02.27